



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 371

Улаанбаатар хот

“Монре даатгал” ХХК-д даатгалын
хэлбэрийн зөвшөөрөл нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.3 дахь заалт болон Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.23 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монре даатгал” ХХК-д итгэлцэл (гүйцэтгэлийн болон урьдчилгаа төлбөрийн баталгаа)-ийн даатгалын хэлбэрийн зөвшөөрөл нэмж олгосугай.

2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Монре даатгал” ХХК /П.Эрдэнэбаатар/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-г, холбогдох өөрчлөлтийг Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл, зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/-г, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-г тус тус даалгасугай.

ДАРГА



НАРАНТУЯА

000990